

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 12/370

НШУС

2011

ИНТЕРНЕТ СЭТГҮҮЛ ЗҮЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

С. Дэлгэрмаа*

* "Их Монгол" дээд сургууль, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор (Ph.D.)

Түлхүүр үг: олон нийтийн санаа бодолд нөлөөлөх, сэтгэгдэл, мульти-медиа, мэдээллийн хэл, эх хэлний дархлаа, сэтгүүлчийн ур чадвар, ёс зүй

Олон нийтийн мэдээллийн харилцааны хэрэгслийн тусламжтайгаар хүлээн авагчдын идэвх санаачилгыг дэмжих, дээшлүүлэхэд нөлөөлөх нь орчин үеийн сэтгүүл зүйн чухал асуудлуудын нэг болж байна. Нийтлэл хэдийчинээ их сэтгэгдэлтэй байна, үр

нөлөө нь төдийчинээ өндөр, олон нийтийн санаа бодолд нөлөөлж, идэвхжүүлж байна гэсэн үг. Монголын нийтлэлчдийн "Баабар.мн" (www.baabar.mn) вэб сайтад олон янзын санаа бодолтой төрөл бүрийн мэргэжилтэй нийтлэлчдийн бүтээлийг блог маягаар байрлуулсан нь хэрэглэгчдийн санаа сэтгэлд ихээхэн нөлөөлдөг бөгөөд энэ нь тухайн нийтлэлд үлдээсэн сэтгэгдлийн тоо, өнгө аясаар илэрч байдаг (хүснэгт 1).

№	Нийтлэлийн нэр	Зохиогч	Нийтлэлийн төрөл	Он, сар өдөр	Сэтгэгдлийн тоо
1	Хотоо хот шиг болгохын хүслэн буюу нэгдсэн ложистик - терминалтай болцгооё	Ш.Даваадорж http://davaadorj.niitlelch.mn/content/1120.shtml	Асуудал дэвшүүлсэн өгүүлэл	2009.12.18	723
2	Элбэгдорж	н.Ганзориг http://ganzorig.niitlelch.mn/content/1151.shtml	Фото зураг	2009.12.24	701
3	Богдын төлөөх тулалдаан	А.Баатархуяг http://baatarhuyag.niitlelch.mn/content/1215.shtml	Өгүүлэл	2010.01.11	690
4	Баабар: Зөв явбал энэ хорвоо зөөлөн шүү дээ	Б.Ганчимэг http://ganchimeg.niitlelch.mn/content/1387.shtml	Ярилцлага	2010.02.18	425
5	Бат-Үүл баатарт "Дутуу бодлоо" гүйцээж илгээх хариу	Х.Баттулга http://battulga.niitlelch.mn/content/1844.shtml	Захидлын хариу	2010.04.23	403

6	Хомо наурус	Б.Батбаяр http://baabar.niitlelch.mn/content/1196.shtml	Өгүүлэл	2010.01.05	284
7	Хүүхдүүдээ, та нарын амь наснаас Ж.Соронзон захирал үнэтэй гэнэ	Л.Мөнхбаясгалан http://munkhbayasgalan.niitlelch.mn/content/1362.shtml	Сэрэмжлүүлэг	2010.02.09	170
8	Философчид босох цаг болжээ!	Э.Бат-Үүл http://batuul.niitlelch.mn/content/1139.shtml	Өгүүлэл	2009.12.22	138
9	Шог зураг	С.Цогтбаяр http://tsogtbayar.niitlelch.mn/content/1209.shtml	Шог зураг	2010.01.08	126
10	Ээжүүд нь бөх шиг дэнж хотойтол амаржиж, хоймортоо автомат бурхан залсан орчин цагийн дуунууд	Д.Болдхуяг http://boldhuyag.niitlelch.mn/content/1083.shtml	Фельетон	2009.12.11	125

Хүснэгт 1. Хамгийн их сэтгэгдэлтэй нийтлэлүүд (2009-2010)
Эх сурвалж: www.baabar.mn

Ялангуяа манай энэ цаг үеийн сайн сэтгүүлчдийн бичсэн нийтлэл олон нийтийн санаа бодолд нөлөөлдөг болох нь олон арваар тоологдох сэтгэгдлээр илрэх бөгөөд тэр хэмжээгээр хүмүүст нөлөөлж, идэвхжүүлж байдаг.

Үндэсний портал "GoGo" мэдээнээс хэрэглэгчийн сонирхлыг хамгийн их татсан, олон сэтгэгдэлтэй нийтлэлийг сонирхож үзэхэд тус сайтын сэтгүүлч М.Жаргалын "Ч.Улаан гишүүн дөрвөн хүний алтан амийг аварчээ" мэдээнд 113 хүн сэтгэгдэл бичсэн байлаа.

Ч.Улаан гишүүн дөрвөн хүний алтан амийг аварчээ

Саяхны нэгэн өдөр Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт орших Ерөө голд нэгэн гэр бүлийн амь насыг аварсан талархууштай хэрэг болсон талаар хүмүүс шуугин ярьж байна.

Тус голын эрэгт гэр бүлээрээ амарч зугаалан явсан Ү.Баатархүүгийн гэр бүлийн дөрвөн хүн усанд живэхээ шахжээ. Эхлээд бага хүү нь хөл алдан усанд унаж хүүгээ аврахаар

араас нь орсон аав нь мөн живж эхэлсэн байна. Энэ үед хоёр хүүхэд нь аав, дүү нараа аврахаар дахин голын усанд орсон ч мөн л тусыг олсонгүй. Гэр бүлээрээ живэх болсон энэ аймшигтай цаг мөчид аврал эрсэн дуудлагыг сонссон УИХ-ын гишүүн Ч.Улаан голын ус руу орж тэднийг ээлж ээлжээр нь аварсан байна.

Ийнхүү нэгэн гэр бүлийн амь насыг аварсан буянтай үйлийг тэрээр хийжээ.

М.Жаргал

Эх сурвалж: GoGo. 2010.06.07

"Ч.Улаан гишүүн дөрвөн хүний алтан амийг аварчээ" гэсэн энэхүү мэдээний доор бичсэн сэтгэгдлээс Интернетэд байдаг сэтгэгдлүүдийн ерөнхий төлөв байдлыг харж болох бөгөөд шинжилж үзэхэд дараах зүйлүүд анхаарал татсан юм. Үүнд:

1. Тухайн мэдээний үнэн бодит байдалд эргэлзсэн 45 хүн байгаа нь нийт сэтгэгдлийн 39% болж байна.

2. Мэдээний гол баатар болох УИХ-ын гишүүн Ч.Улааны нэр төр, нутаг ус, найз нөхдийг гутаан доромжилсон утга агуулгатай 26 сэтгэгдэл.

3. Нийт 113 сэтгэгдлээс 57-д нь үг үсэг, зөв бичих дүрэм, хэл найруулгын алдаа их байгаа нь харагдлаа. Бүдүүлэг үг хэллэг, хараал хэрэглэсэн 5 сэтгэгдэл байна.

4. Хүний нэрийн өмнөөс бичсэн 3 сэтгэгдэл, тухайлбал Ч.Улаан гэсэн нэрээр сэтгэгдэл бичсэн байв.

5. Сэтгүүлчийн ур чадварыг сайжруулах, нийтлэлийн үр өгөөжийг дээшлүүлэх талаар анхааруулсан сэтгэгдэл 2 байна.

Манай Интернет сэтгүүл зүйн мэдээ мэдээллийн өнгө үзэмж өдрөөс өдөрт сайжирч, фото, аудио, видео хэлбэрээр мэдээгээ тавих явдал нэмэгдэж байгаа нь сайшаалтай хэрэг юм. Харин дээрх мэдээний үнэн бодит байдалд хэрэглэгчид итгэхгүй, эргэлзэж байгаа нь сэтгэгдлүүдээс байна. Мэдээний үнэн бодит байдалд эргэлзсэн нь технологи хөгжсөн өнөө цагт ямар ч мэдээ, мэдээллийг мультимедиа хэлбэрээр байрлуулах боломжтой гэдгийг вэб сайтад ажилладаг сэтгүүлчид анхаарахгүй байгаатай холбоотой гэж үзэж болно. Манай Интернет сэтгүүл зүйн хамгийн том дутагдал үүнд оршдог бөгөөд энэ нь угтаа тухайн сэтгүүлчийн ур чадвартай холбоотой асуудал юм. Уншигчийнхаа сэтгэгдлийг уншаад эргээд уг үйл явдлыг гэрчлэх эх сурвалжуудаас видео хэлбэрээр ярилцлага авч тавих зэргээр Интернет сэтгүүл зүйн давуу талыг гаргаж, эргэх холбоотой ажилласан бол үнэхээр үр дүнтэй болох байлаа. Доктор Я.Борчулуун Монголын сэтгүүлчдэд аливаа үйл явдлыг байнга мэдээлэх явдал дутагдаж байгааг “Ньюс.мн” сайтын сэтгүүлч Д.Цэпилмаатай хийсэн ярилцлагадаа онцлон, барууны хэвлэлд үйл явдлыг нэг удаа мэдээлээд орхих бус, тухайн үйл явдал өрнөж байгаа бол үйл явц болгоныг дуустал

нь мэдээлдэг. Харин манайд мэдээллийг байнга шинэчлэх ажиллагаа үгүйлэгдэж байгаа бөгөөд энэ нь нэг талаас хүн хүчний дутмаг байдлаас шалтгаалдаг байхыг үгүйсгэхгүй гэжээ. Энэ талаар тодруулж үзэхэд вэб сайтын мэдээ, мэдээллийг оруулдаг сэтгүүлчдэд редакцияас өдөрт дунджаар 100-180 мэдээ бичих үүрэг өгдөг болохыг “Шууд.мн”, “Ньюс.мн” сайтад ажилладаг сэтгүүлчдээс асууж тодруулсан юм. Мөн “Ньюс.мн” сайтын архивт байгаа мэдээ, мэдээллийг сар сараар нь гаргаж харахад дунджаар 4000-6000-ын хооронд хэлбэлздэг нь ажиглагдлаа. Үүнийг нэг өдөрт тооцож бодоход дунджаар 100-200 гэсэн тоо гарч байгаа нь дээрх сэтгүүлчдийн хэлсэн тоотой яг таарч байна.

Ер нь манай портал сайт, Интернет сонин сэтгүүлийн мэдээг ихэвчлэн нэг, хоёр сэтгүүлч, эсвэл тухайн вэбийг хариуцсан хүн бэлтгэдэг нь нууц биш бөгөөд тэд өдөрт дор хаяж 50, дээд тал нь 100 мэдээ бэлтгэж оруулдаг гэсэн үг билээ. Өдөрт 50-100 мэдээ олно гэдэг нь эрүүл ухаанд багтах ааргүй үзэгдэл тул ном, цаасан сонин, сэтгүүл болон бусад вэб сайт, блогос мэдээлэл хуулж тавихад хүргэдэг байх талтай. Мэдээний тооны хойноос биш, харин мэдээлэл хэмээх онцгой төрлийн бараа бүтээгдэхүүнийхээ чанарт анхаарч ажиллах ёстой болохыг мэдээллийн бизнес эрхэлдэг вэб сайтын эзэд, вэб редакцийн эрхлэгч нар анхаарах нь зүйтэй. Өөрсдөө бэлтгэхгүйгээр олон төрлийн мэдээллийн эх сурвалжаас мэдээ материал цуглуулан хэрэгтэй, хэрэггүй маш олон мэдээлэл тавьж байгаа нь эцэстээ хэрэглэгчээ алдахад хүргэх аюултай юм. Учир нь тэр олон мэдээлэл дундаас өөрт хэрэгтэйгээ сонгон авч унших нь тухайн хэрэглэгчийн эрхийн асуудал төдийгүй, хүмүүст өгөөжгүй мэдээлэл цацдаг вэб сайтуудыг уншигчид орхих нь гарцаагүй.

Мэдээний доод талд байгаа сэтгэгдлийг тухайн мэдээллийг бэлтгэсэн сэтгүүлч маань өөрөө огт уншдаггүй, үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийдэггүй тал ажиглагдаж байна. Мөн эргээд сурвалжлах, нийтэлсэн мэдээнийхээ эцсийн үр нөлөөг хүртэхийн төлөө шургуу ажиллах чадвар Интернет мэдээллийн хэрэгслийн ажилтнуудад дутагдаж байгаа гэж үзэж болох юм. Учир нь сэтгүүлчдийн бичсэн мэдээ, мэдээллийг хэрэглэгчид өөрсдөө үнэлэн цэгнэж байгаа нь Интернет сэтгүүл зүйн давуу тал бөгөөд эргэх холбоотой, интерактив хэвлэл мэдээллийн салбар хөгжиж байгааг илэрхийлнэ. “Comment” буюу уншигчийн сэтгэгдлээс санаа авах зүйл их байдгаас гадна иргэний сэтгүүл зүйн үндэс эндээс гарах сайн талтай гэж үзэх болсноор барууны сэтгүүл зүйд иргэдийн санаа бодлыг их хэмжээгээр тусгаж, зарим идэвхтэй уншигчийн блогийг өөрийн сайтдаа холбох зэргээр вэб сайтын үйл ажиллагааг улам сайжруулах хандлага ажиглагдаж байна.

Вэб сайтад тавигдсан мэдээ материалд уншигчдын сэтгэгдлийг зочин нэрийн дор тодорхой нэр хаяггүй, эсвэл хүний өмнөөс хүссэн зүйлээ бичиж үлдээх боломж олгодог билээ. Гэвч манай зарим уншигчийн Интернетийн соёл хангалтгүй байгаагаас бичсэн зүйлийг үгүйсгэсэн, хүмүүсийг элдвээр доромжилсон, ёс зүйгүй авирласан байдал их хэмжээгээр гарч байгааг дээрх мэдээний сэтгэгдлээс харж болно. Ийм учраас хүмүүс бодит мэдээллийг түргэн шуурхай, хямд олж авах шинэ гарц, боломжуудыг өргөн ашиглах болсон нь блог болон нийг-

мийн сүлжээ сайтуудад ихээр татагдах нөхцлийг бүрдүүлсэн байх талтай юм.

Мэдээллийн ямар ч хэрэгсэл байсан хэлээр дамжиж, мэдээллээ хүргэдэг билээ. Мэдээллийн хэл нь мэдээлэх, харилцах, нөлөөлөх гэсэн гурван үүрэгтэй бөгөөд аливаа хэлэнд тавигдах шаардлага ерөнхийдөө ижил боловч мэдээллийн хэлний хувьд сонины, сэтгүүлийн, телевизийн, радиогийн, Интернетийн хэл найруулга нь тус тусдаа өөрийн өнгө төрх,

өвөрмөц онцлогтой байх нь тодорхой билээ. Энэ чиглэлээр судалгаа хийдэг МҮОНТ-ийн сэтгүүлч, доктор Б.Нацагдорж “Манай улс өөрийн хэл соёлоо дээдлэн үзэж, юуны түрүүнд бичгийн хэлээ эмх цэгцтэй, дүрэм журамтай байлгахаар төрийн хууль тогтоол гаргаж, түүнийгээ бүх нийтээр мөрдүүлдэг” гэсэн юм. Тэгвэл дээрх мэдээний 113 сэтгэгдлээс 57-д нь үг

үсэг, хэл найруулгын алдаа ажиглагдаж байна. Тодруулбал, зөв бичих дүрмийн алдаа ихтэй, хэл найруулга төгс бус, бүдүүлэг үг хэллэг, хараал хэрэглэсэн, монгол кирилл үсгийн фонт UNICODE ашигладаг гэдгийг мэддэггүй, англи үсгээр галиглан хөрвүүлэхдээ “Монгол кирилл үсгийг романчлах” дүрмийг баримтлаагүй бичжээ. Манай вэб сайтуудад ийм алдаа асар их байгааг бид мэдэж байгаа боловч түүнийг засч залруулах ажил төдийлөн сайн хийгдэхгүй байна. Өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэлний бодлого алдагдаж, тэр нь Интернетийн орчинд бүр ч илүү тод ажиглагдах болжээ. Ийм байдал үргэлжилсээр байвал монгол хэлний дархлаанд

«

*Манай сэтгүүлчид тэр дундаа
Интернет сэтгүүлчид
мэдээллийн үйлдвэрлэлд чанаргүй
гологдол бүтээгдэхүүн гаргаж,
хүлээн авагчдын оюуны хэрэгцээ,
шаардлагыг хангаж чадахгүй
байгаагийн улмаас тэдний
мэргэжлийн байр суурь алдагдах
болж, хүлээн авагчдын элэг доог,
тохуу хийсэн сэтгэгдэл олноор
төрөн гарахад хүргэж байна.*

»

муугаар нөлөөлж, монгол ч биш, англи ч биш хэлээр үр хойч маань ярих, улмаар үндэсний аюулгүй байдал алдагдахад хүрэх болно.

Мөн түүнчлэн дийлэнх хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн эвсэл хүчинд үйлчилдэг, тэднийг хамгаалдаг явдал газар авсан нь мэдээллийн тэнцвэрт байдалд алдагдахад хүргэж, асуудлын нэг талыг барьж туйлшрах явдал энгийн үзэгдэл болсон байна. Орчин цагт Интернетээс хүмүүс цаг алдалгүй, уян хатан байдлаар авах боломжтой болж, хувь хүмүүс болон хэвлэлийн бус байгууллагаас уламжлалт ХМХ-ийг зах зээлээс шахах, тэдний хооронд өрсөлдөөн үүсч, хүн бүхэн мэдээ бичиж, хялбархан тараах боломжтой технологи бий болсон юм. Мэдээллийн үнэ цэнэ, ач холбогдол өдрөөс өдөрт улам бүр нэмэгдэж, дэндүү хурдтай даяарчлагдаж, технологийн хөгжлийн нөлөөгөөр хүмүүсийн мэдээлэл хүлээн авах боломж улам сайжирч, мэдлэг боловсрол, соёлын төвшин эрс дээшилж байгаа өнөө үед аливаа мэдээ мэдээллийн багтаамж, чанар, ур чадварын асуудал үнэхээр чухал билээ. Гэтэл манай сэтгүүлчид тэр дундаа Интернет сэтгүүлчид мэдээллийн үйлдвэрлэлд чанаргүй гологдол бүтээгдэхүүн гаргаж, хүлээн авагчдын оюуны хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байгаагийн улмаас тэдний мэргэжлийн байр суурь алдагдах болж, хүлээн авагчдын элэг доог, тохуу хийсэн сэтгэгдэл олноор төрөн гарахад хүргэж байна.

Интернет болон мэдээллийн технологийн өндөр боломж, давуу талыг дэлхийн төвшинд ашиглаж, чанар сайтай, ур чадвар бүхий мэдээллийн бүтээгдэхүүн гаргахыг хэрэглэгчид шаардаж байна. Иймд тодорхой нэг сэдэв, нэг асуудлыг

хөндөж, олон талаас нь сурвалжилсан сэтгүүлчдийн баг мэдээллээ текст, видео, аудио, фото хэлбэрээр нэгтгэн, цогц байдлаар хэрэглэгчид хүргэхийн дээр энгийн хүмүүсээс илүү бичлэгийн ур чадвартай, эх хэл соёлоо хүндэтгэсэн, хүнлэг энэрэнгүй, ёс зүйтэй байх нь манай өнөөгийн Интернет сэтгүүл зүйн гол тулгамдсан асуудал болж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.
2. Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл. УБ.
3. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. I боть. УБ.
4. Наранбаатар Б. 2009. Мультимедиа сэтгүүл зүйг Монголд төлөвшүүлэх асуудалд // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, №319 (56).
5. Нацагдорж Б. 2010. Мэдээллийн хэл булингартах учиргүй //www.mongolnews.mn
6. Норовсүрэн Л., Энхтуяа Х. 2008. Иргэний сэтгүүл зүй. УБ.

Summary

Owners of this kind of business and editors should pay attention for informative quality and should not suppose the amount of news. At present, media language policy has lost and it has been observed by online journalism. Thus, linguistic scholars have to define media language police appropriately and plan to solve the urgent issues. The research analysis has shown that nowadays, online press became enough to comprise intellectual class of society and accessible for public. Mostly, one or two journalist release of the news and it means 50-100 news a day. It is impossible to provide the same amount of news so it is understood that the website staff copy from newspapers, other websites, blogs and social network.